

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГГИЖ БУЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД БАРИМТ БИЧГҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2026.02.24

д/д	Баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Эрх зүйн актын дугаар	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилтийн явцын товч тайлбар (хувь, гол үр дүн, тулгамдсан асуудлыг 2-3 өгүүлбэрээр)
<b>Нэг. Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд</b>					
1	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай	2020.05.13	УИХ-ын 52 дугаар тогтоол		<p>“Замын-Үүд” чөлөөт бүсэд нэн тулгамдаж буй асуудлууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Хил, гааль, хяналтын байгууллагуудын нэг цонхны үйлчилгээний зарчим хэрэгжээгүй, тус тусдаа үйл ажиллагаа явуулж байна</li> <li>➢ Чөлөөт бүс доторх дэд бүтцийн байгууламжуудын туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг хийхэд шаардлагатай 1,5 тэрбум төгрөгийн зардлын төсвийг шийдвэрлэх             <ul style="list-style-type: none"> <li>○ <b>Дулаан хангамж:</b> Чөлөөт бүс дотор дулааны магистрал шугам тавьсан хэдий ч дээрх шугамын гэмтлийн улмаас ашиглаагүй байгаа. Засвар хийсний дараа туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг хийх</li> <li>○ <b>Ус хангамж:</b> 2014 онд ашиглалтад орсноос хойш ашиглаагүй, ус цэвэршүүлэх мембрам, эсрэг осмусийн шүүлтүүрүүдийг солих, туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг хийх Мөн байнгын ажиллах хүч, холбогдох урсгал зардлыг шийдвэрлэх шаардлага бий.</li> <li>○ <b>Ариутгах татуурга:</b> 2017 онд ашиглалтад орсноос хойш Замын үүд сумын бохирыг татан зайлуулж байна. Чөлөөт бүсийн байрлалд 2-р хэлхээний</li> </ul> </li> </ul>

					бохирын шугам ашиглалтад орсны дараа туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг хийх
2	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийг үндсэн чиглэл батлах тухай	2020.08.28	УИХ-ын 23 дугаар тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>• Зорилт 4.4.1 Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын эдийн засгийн коридорыг хөгжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ гэж заасны дагуу “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг хооронд нь холбох, улсын хилийн шугамыг огтлон гарах цэгийн байршлыг тогтоох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.</li> <li>• Зорилт 8.1.5 чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд “Замын-Үүд” чөлөөт бүсэд 102 аж ахуйн нэгжид худалдаа, аялал жуулчлал, агуулах, тээвэр логистик, үйлдвэрлэл гэсэн 4 чиглэлээр нийт 148,71 га газрыг 2016-2025 оны хооронд олгосон. Байнгын үйл ажиллагаа эрхэлж байгаа 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 6 аж ахуйн нэгжийн барилга байгууламж баригдах шатанд, 54 аж ахуйн нэгж зураг төслөө боловсруулах шатанд үйл ажиллагаа явуулж байна.</li> </ul>
3	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	2024.08.27	УИХ-ын 21 дүгээр тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>• 1.2.1.1 зорилтын хүрээнд "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зургийн даалгаврыг боловсруулсан. Монгол Улсын Шадар сайд, Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд нараар 2025/03 дугаарын зургийг даалгаврыг батлуулсан. "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зургийн даалгаврын дагуу Төрийн худалдан авах газраас тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр нээсэн боловч төсвийн хэмнэлт хийхтэй холбогдуулан санхүүжилт зогсоосон.</li> </ul>
4	Монгол Улсын хөгжлийн	2024.10.18	УИХ-ын 35		<ul style="list-style-type: none"> <li>• 1.2.3.13. Замын-Үүд, Алтанбулаг болон бусад</li> </ul>

	2025 оны төлөвлөгөө батлах тухай		дугаар тогтоол		<p>чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөгөөг сайжруулж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ гэсэн хүрээнд 2025 он 10 сарын 01 өдөр Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтран хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг баталсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>1.2.3.15. "Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийг Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүс нутгуудын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрчимжүүлнэ гэж заасны дагуу "Замын-Үүд" чөлөөт бүс одоогийн байдлаар "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийг хооронд нь холбох, улсын хилийн шугамыг огтлон гарах цэгийн байршлыг тогтоох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.</li> </ul>
5	Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	2025.02.14	Шадар сайдын 25 дугаар тушаал	2025-2028	<ul style="list-style-type: none"> <li>2.5.3.1 Чөлөөт бүсүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх хүрээнд 2025 он 10 сарын 01 өдөр Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтран хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг баталсан</li> <li>2.5.3.2 Чөлөөт бүсэд бүс нутгийн болон олон улсын эдийн засгийн сүлжээнд холбох гарцыг нээх, хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн боломжийг бүрдүүлэх хүрээнд "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийг хооронд нь холбох, улсын хилийн шугамыг огтлон гарах цэгийн байршлыг тогтоох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна</li> <li>2.5.3.3 Чөлөөт бүсэд олон улсын стандартын үйлдвэрлэл, үйлчилгээ нэвтрүүлэх, худалдаа, бараа бүтээгдэхүүний эргэлтийг нэмэгдүүлэх хүрээнд одоогийн байдлаар чөлөөт бүсэд 102 аж ахуйн нэгжид худалдаа, аялал жуулчлал, тээвэр логистик, үйлдвэрлэл гэсэн 4 чиглэлээр нийт 156,6 га газрыг 2016-2025 оны хооронд олгосон.</li> </ul>

					<p>Байнгын үйл ажиллагаа эрхэлж байгаа 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 6 аж ахуйн нэгжийн барилга байгууламж баригдах шатанд, 54 аж ахуйн нэгж зураг төслөө боловсруулах шатанд үйл ажиллагаа явуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>2.5.3.6 Чөлөөт бүс дэх төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх тогтолцоог бий болгох хүрээнд чөлөөт бүсэд 2025 оны байдлаар өдөрт 206, жилд 59377 тээврийн хэрэгсэл, өдөрт 660, жилд 190856 зорчигч нэвтэрч байна. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд сард 1,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн дүнтэй байна. Замын үүд чөлөөт бүс 2015-2025 онд газрын төлбөр, бусад хураамжийн орлогоос 3,7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.</li> </ul>
<p><b>Хоёр. Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжиж буй, УИХ, Засгийн газраас батлагдсан бусад баримт бичгүүд, Шадар сайдын тушаалаар батлан салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй бодлогын асуудал зохицуулсан тушаал шийдвэр (хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө, баримт бичиг г.м)</b></p>					
1	“Замын-Үүд” чөлөөт бүсийн стратеги төлөвлөгөө	2025.06.24	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал		<ul style="list-style-type: none"> <li>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Ардын Засгийн газартай “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн “Хамтран хөгжүүлэх төлөвлөгөөний төсөл”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.</li> <li>“Замын-Үүд” чөлөөт бүс одоогийн байдлаар “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг хооронд нь холбох, улсын хилийн шугамыг огтлон гарах цэгийн байршлыг тогтоох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна</li> <li>Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн “Арга хэмжээ зохион байгуулах тухай” 154 дүгээр тушаалыг үндэслэн Монгол</li> </ul>

					<p>, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хоёрдугаар хуралдааныг Шадар Сайдын ажлын албатай хамтран 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.</p> <ul style="list-style-type: none"> <li>• “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн төлөөллийг БНХАУ-ын Танжин хотын бизнес эрихлэгчдийн төлөөлөлтэй холбох, хамтран хөрөнгө оруулалт хийх талаар уулзалтыг 2025 оны 07 дугаар сарын 02-оос 07-ны өдрийн хооронд зохион байгуулав</li> <li>• АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн Зорилт-1 /CS01 Дэд бүтэц болон барилга байгууламж барьж ашиглалтад оруулах – 18.50 % Зорилт-2 /CS02/ Тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих – 50 % Зорилт-3 /CS03/-ын Чөлөөт бүсэд нэвтрэх системийг байгуулах – 100 %, Нийт гүйцэтгэл 54 % тай үргэлжилж байна. Нийт 13 тайлан, биелсэн 8 тайлан, цуцлагдсан 4 тайлан, хүлээгдэж буй 1 тайлан</li> <li>• Замын-Үүд чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зургийн даалгаврын дагуу Төрийн худалдан авах газраас тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр нээсэн боловч төсвийн хэмнэлт хийхтэй холбогдуулан энэхүү төсөл арга хэмжээ санхүүжилтийн эх үүсвэргүй болсон тул хэрэгжүүлэх боломжгүй болсон</li> <li>• Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгах 3 арга хэмжээг тайлбар үндэслэлийн хамт боловсруулж 2025 оны 01-р сарын 13-нд Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.Үүнд:</li> </ul>
--	--	--	--	--	--

					<ul style="list-style-type: none"><li>• “Замын-Үүд” чөлөөт бүс рүү салаа төмөр зам оруулах ТЭЗҮ, зураг төсөв хийлгэх</li><li>• Замын-Үүд чөлөөт бүсийн 1.2.5.6-р хэсэгт хийгдэх 2-р ээлжийн дэд бүтцийн авто зам, дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуургын зураг төсөвт тододтол хийх, санхүүжилтийг шийдвэрлэх</li><li>• АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийг үргэлжлүүлэх.</li></ul>
--	--	--	--	--	--

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮСНЭГТ

№	Баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Эрх зүйн актын дугаар	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилтийн явцын товч тайлбар
1	Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтран хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө	2025.10.01	115	2019 – 2035 он	Үйл ажиллагаа эхлээгүй
2	“Замын-Үүд” чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө	2011.06.22	Засгийн газрын 187 дугаар тогтоол	2009-2029 он	<p>“Замын-Үүд” чөлөөт бүсийн дэд бүтцийг сайжруулах төслийн хүрээнд 2009-2019 онд дараах бүтээн байгуулалтыг хийсэн. Үүнд: 110/10 кВ-ын цахилгааны дэд станц, 18 дэд өртөө, цахилгааны шугам 90 мГВ хүчин чадалтай Замын үүд дулааны станц, дулаан түгээх 12 дэд төв, шугам сүлжээ, Ус цэвэршүүлэх үйлдвэр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, өргөх станц, шугам сүлжээ</p> <p>Чөлөөт бүс дотор 13,5 км хатуу хучилттай автозам, явган зам, гэрэлтүүлэг, холбооны сувагчлалийн дэд бүтцийн ажил хийсэн.</p> <p>2019-2029 онд хийгдэх 2-р ээлжийн дэд бүтцийн зураг төсөл хийгдсэн</p>

					Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс болон өөрчлөгдөхтэй холбогдуулан мастер төлөвлөгөөнд өөрчлөлт хийх шаардлага үүссэн
--	--	--	--	--	---